



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 09 өдөр

Дугаар АА2

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай


Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, Захиргааны зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн "МУИС-ийн магистрант, докторантын эрдэм шинжилгээ, дадлагын ажлын багц цаг тооцоход баримтлах түр журам"-ыг хавсралтаар баталж, 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт эрхэлсэн дэд захирал (Г.Баярмагнай), Төгсчлтийн дараах сургуулийн захирал (Б.Отгонтөгс) нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТРАНТ,
ДОКТОРАНТЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ДАДЛАГЫН
АЖЛЫН БАГЦ ЦАГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ТҮР ЖУРАМ**

МУИС-ийн магистрант, докторантын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хамгаалах болон бусад холбогдох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү түр журмыг МУИС-ийн бусад дүрэм, журамтай нийцүүлэн мөрдөнө.

Эрдэм шинжилгээний багц цаг тооцох

1. Магистр, докторын эрдэм шинжилгээний багц цагийг сургалтын журмын 4.5.15-д заасны дагуу сонгон баталгаажуулна.
2. Эрдэм шинжилгээний багц цаг тооцох комиссыг З-аас цөөнгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар томилно.
3. Эрдэм шинжилгээний багц цаг цуглувансан тухай удирдагчийн тодорхойлолт болон батлах судалгааны материал, өгүүллүүдийг үндэслэн комисс магистрант, докторантын эрдэм шинжилгээний багц цагийг тооцно.
4. Магистрантын эрдэм шинжилгээний багц цагийг тооцоходоо тэнхмийн эрдэм шинжилгээний төлөвлөгөөт семинар, их семинарт оролцсон бол тус бүр 0,1 багц цаг, туршилт судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнг тэнхмийн эрдэм шинжилгээний семинарт илтгэж хэлэлцүүлсэн бол 1 багц цаг, их сургуулиудын болон эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний хуралд илтгэж хэлэлцүүлсэн бол 2 багц цаг, олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн бол 4 багц цаг, хэвлүүлсэн бол 3 багц цаг, олон улсын редакцийн зөвлөл бүхий гадаад хэл дээр хэвлэгддэг эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бол 4 багц цаг, туслах судлаачаар ажилласан бол 2 багц цаг биелүүлсэнд тооцно.
5. Докторантын эрдэм шинжилгээний багц цагийг тооцоходоо туршилт судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнг сургуулийн хэмжээний эрдэм шинжилгээний хуралд илтгэж хэлэлцүүлсэн бол 1 багц цаг, улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд илтгэж хэлэлцүүлсэн бол 1.5 багц цаг, олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн бол 2 багц цаг, Эрдмийн зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн хуралд хэлэлцүүлсэн бол 3 хянан магадлагaa хийгддэг дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бол 3

багц цаг, олон улсын редакцийн зевлөл бүхий гадаад хэл дээр хэвлэгддэг сэтгүүлд хэвлүүлсэн бол 4 багц цаг, гадаадад монограф хэвлүүлсэн бол 10 багц цаг, дотоодод монограф хэвлүүлсэн бол 8 багц цаг, Томсон-Ройтерсийн индексгүй боловч мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 8 багц цаг, Томсон-Ройтерсийн индекстэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 10 багц цаг, туслах судлаачаар ажилласан бол 2 багц цаг биелүүлсэн тооцно. Ном, гарын авлага, сурх бичгээр багц цаг тооцохгүй.

УХД0072 9104359

6. Докторантын хэвлүүлсэн бүтээлийг эрдэм шинжилгээний багц цагт тооцож болох тухайн салбарын мэргэжлийн түвшинд хянагддаг /peer-review/ болон хянагддаггүй сэтгүүлийн жагсаалтыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зевлөл шийдвэрлэнэ. Эдгээр сэтгүүлийн жагсаалтанд beall-ийн жагсаалтанд багтах хуурамч сэтгүүлүүдийг оруулахгүй.

7. Өгүүлэл нь хэвлэхээр зөвшөөрөгдсөн, сэтгүүлийн албан ёсны захиаг ирүүлсэн тохиолдолд эрдэм шинжилгээний багц цагт тооцно.

8. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний багц цагийн үнэлгээг комиссын дүгнэлтийг үндэслэн комиссын нарийн бичгийн даргын баталгаажуулснаар бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны дарга сургалтын мэдээллийн системд тооцов буюу S тэмдэглэгээгээр оруулна.

9. Эрдэм шинжилгээний багц цаг болон судалгааны ажлыг сонгон баталгаажуулсан боловч гүйцэтгэж амжаагүй бол цуцалж болох бөгөөд төлбөрийг суутгахгүй. Төлбөрийн зөрүүг суралцагч хариуцна.

Магистрын хөтөлбөрийн мэргэжлийн дадлага хийх, хамгаалах

1. Мэргэжлийн магистрын хөтөлбөрийн дадлагын удирдамжийг тухайн мэргэжлийн онцлогоос хамааруулан тэнхмийн эрхлэгч/хөтөлбөрийн ахлагч боловсруулж, бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

2. Дадлагын удирдамжид хөтөлбөрийн нэр, индекс, багц цаг, дадлагын ажлын зорилго, эзэмшүүлэх мэдлэг, чадвар түүнийг үнэлэх нарийвчилсан шалгуур үзүүлэлтүүд, дадлагын хугацаа, зохион байгуулах хэлбэр, газар, маршрут, ажлын болон амралтын цаг, аюулгүй ажиллагааны нөхцөл, тайлангийн бүтэц зэргийг тодорхойлно.

3. Мэргэжлийн дадлагыг удирдах багш, магистрантуудын нэр, хийх хэлбэр, байгууллага зэргийг тэнхим нэгтгэж бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

4. Мэргэжлийн магистрант нь дадлагын ажлыг сургалтын журмын 4.5.15-д заасны дагуу сонгон баталгаажуулна.

5. Мэргэжлийн дадлагын ажлыг магистрант удирдамжийн дагуу удирдагч багшийн удирдлага дор гүйцэтгэх бөгөөд тайланг 3-аас доошгүй гишүүнтэй комисст хамгаална. Комиссыг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар томилно.

6. Комисс нь дадлагаар эзэмшсэн мэдлэг, чадварыг удирдамжийн дагуу үнэлэх ба гишүүдийн дундаж үнэлгээ 60-аас дээш бол "хангалттай" гэж үзэн магистрын дадлагын ажил хамгаалсан тухай тогтоол гаргана.

7. Дадлагын тайлан хамгаалуулах комиссын тогтоолыг үндэслэн дунг сургалтын мэдээллийн системд дадлага удирдсан багш оруулна.

8. Магистрантын 8 оюутны 1 багц цагийн дадлага удирдсан багшийн А цагийн үнэлгээг 0.1 багц цаг гэж тооцно.

Магистрын ажлын урьдчилсан хамгаалалт

1. Магистрын ажил нь сургалтын журмын 3.7.6-д зааснаар тодорхойлогдоно. Магистрын ажлын урьдчилсан хамгаалалтыг хөтөлбөрийн хэлэлцүүлгээр хийнз.

2. Урьдчилсан хамгаалалтаар магистрантыг жинхэнэ хамгаалалтанд оруулах тухай зөвлөмж, шийдвэрийг гаргана.

3. Урьдчилсан хамгаалалтаар тухайн магистрантын ажлын үр дүн, магистрын ажлын бичлэгийн шаардлагыг хангасан эсэх, хэлэлцүүлгийн явцад гарсан санал, шүүмж нь тухайн магистрантын зэрэг хамгаалах ажилд их хэмжээний өөрчлөлт хийхээр нөхцөл үүсгэх эсвэл үр дүн алдаатай, судалгааны болоод сэдвийн хувьд алдаатай гэж үзвэл тухайн ажлыг жинхэнэ хамгаалалтын шаардлагыг хангаагүй хэмээн үнэлж, цаащдын хэлэлцүүлэгт оруулахаас татгалзана.

4. Дээрх заалтын шаардлагыг биелүүлсэн бөгөөд тухайн магистрантын хэлэлцүүлэхээр бэлдсэн ажил нь бичиглэлийн техникийн засвар болон утга найруулга зөргээс бусад үндсэн үр дүнг хамгаалуулах зөвлөлийн гишүүд зөвшөөрсөн бол уг ажлыг жинхэнэ хэлэлцүүлэгт оруулахаар шийдвэрлэнэ.

Магистрын төгсөлтийн ажлын жинхэнэ хамгаалалт

1. Магистрын ажлын жинхэнэ хамгаалалтыг Магистрын ажил хамгаалуулах зөвлөлд хамгаална.

2. Тухайн хөтөлбөрийг хариуцсан ахлагчийн санал болгосны дагуу бүрэлдэхүүн сургуулийн захирлын шийдвэрээр Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийг 4-5 докторын зэрэгтэй багшийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

3. Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгзээс багагүй нь мэргэжлийн өөр тэнхим, гадны байгууллага, сургуулийн төлөөлөл байна.

4. Салбар дундын судалгааны сэдвэр хамгаалах магистрантын хувьд Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийг сонгон судалсан хичээлийн багтаамж, холбогдох тэнхмүүдийн саналыг үндэслэн хөтөлбөр нь байршиж буй бүрэлдэхүүн сургуулийн захирал шийдвэрээр байгуулна.

5. Магистрын ажил хамгаалуулах зөвлөл БСШУ-ны сайдын 2007 онд баталсан "Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл"-ийн тухай дурмийн хүрээнд ажиллана.

УХД0072 9104399

6. Магистрын ажил хамгаалуулах хуралдаанд оролцсон гишүүдийн 75-аас доошгүй хувийн зерэг санал авсан тохиолдолд тухайн ажлыг шаардлага хангасан гэж үзнэ.

7. Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны протокол, шийдвэрийг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албан хүргүүлнэ.

8. Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн жинхэнэ хамгаалалтын хуралдаан Сургалтын журмын 3.7.6-д заасан шаардлагыг хангаагүй ажлыг хэлэлцэхгүйгээр буцаах эрхтэй.

9. Магистрын ажлаа хамгаалж чадаагүй бол магистрант 2 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтанд орох хүсэлтээ суралцагч бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны эрхлэгчид гаргах ба тэнхмийн эрхлэгч/хөтөлбөрийн ахлагчийн саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар зөвшөөрөл олгоно.

Докторын диссертацийн урьдчилсан хамгаалалт

1. Докторын диссертаци сургалтын журмын 3.8.7-д зааснаар тодорхойлогдоно. Докторант диссертация тэнхим/хөтөлбөрийн эрдэм шинжилгээний өргөтгөсөн семинараар хэлэлцүүлнэ.

2. Удирдагч нь зөвшөөрсөн тохиолдолд, тэнхмийн/хөтөлбөрийн эрдэм шинжилгээний өргөтгөсөн семинараар амжилттай хэлэлцүүлсэн, гарсан санал, шүүмжийн дагуу засварыг бүрэн хийсэн докторант тэнхим/бүрэлдэхүүн сургуулийн өргөтгөсөн их семинарт урьдчилсан хамгаалалт хийнэ.

3. Их семинарыг тухайн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар томилогдсон профессор хичээлийн жилийн туршид батлагдсан хуваарийн дагуу удирдан явуулна. Өргөтгөсөн их семинарт тухайн чиглэлийн хамгаалуулах зөвлөлийн гишүүдийг оролцуулахыг чухалчилна.

4. Их семинараас горилогчийн диссертацид мэргэжлийн дүгнэлт хийж, жинхэнэ хамгаалалтанд оруулах тухай шийдвэрийг хуралдааны протоколоор баталгаажуулна. Энэ нь Докторын ажил хамгаалуулах зөвлөлд МУИС-иас гаргах хүсэлтийн нэг үндэслэл болно. Урьдчилсан хамгаалалтаас гарах шийдвэр нь тухайн докторантын диссертаци сургалтын журмын 3.8.7-д заасан шаардлагыг хангасан, жинхэнэ хамгаалалтад орох шаардлага хангасан, эс хангасан тухай байна.

5. Их семинар удирдсан профессорын удирдлага дор семинарт оролцсон багш, профессор, тухайн чиглэлийн хамгаалуулах зөвлөлийн гишүүд уг горилогчийн ажлын үр дүн, диссертацийн бичлэгийн шаардлагыг хангасан эсэх, хэлэлцүүлгийн явцад гарсан санал, шүүмж нь тухайн докторантын ажилд их хэмжээний өөрчлөлт хийхээр нехцэл үүсгэх эсвэл үр дүн алдаатай, судалгааны болоод сэдвийн хувьд алдаатай гэж үзвэл жинхэнэ хамгаалалтад орох шаардлага эс хангасан тухайг хурлын протоколоор баталгаажуулна.

6. Докторын ажлын жинхэнэ хамгаалалтыг БСШУ-ны сайдын 2014 онд баталсан "Докторын ажил хамгаалуулах зөвлөл"-д хамгаална. Докторын ажил хамгаалуулах зөвлөлийн хуралдаан БСШУ-ны сайдын 2010 онд баталсан "Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл"-ийн тухай дүрмийн хүрээнд явагдана.

7. Докторын ажил хамгаалуулах зөвлөлөөс албан ёсны 2 шүүмжлэгчийг томилно.

УХД0072 9104399

Докторын ажил хамгаалуулах зөвлөлд МУИС-иас өгөх зөвшөөрөл

1. Докторант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, гадаад хэлний шалгалтаа өгсөн, сургалтын төлбөрөө төлсөн, диссертацийн ажлаа тэнхим/профессорын баг, бүрэлдэхүүн сургуулийн өргөтгөсөн их семинарт амжилттай хэлэлцүүлсэн бол жинхэнэ хамгаалалтад орох зөвшөөрөл хүсэх өргөдлөө МУИС-ийн Төгсeltийн дараах сургуульд уламжлах ба дараах материалыудыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- 1.1 Бакалавр, магистрын зэргийн дипломын хуулбар /нотариатаар баталгаажуулсан байх/
- 1.2 Бүтээлийн жагсаалт /удирдагчийн гарын үсэг зурагдаж баталгаажсан байх/
- 1.3 Докторантаар элссэн болон шилжилт хөдөлгөөн хийгдсэн захирлын тушаал
- 1.4 Сургалтын ганцаарчилсан төлөвлөгөө
- 1.5 Сэдэв баталсан, удирдагч томилсон бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаал
- 1.6 Шалгалтын комиссыг баталгаажуулсан тушаал /2011 оноос өмнөх элсэгчдэд хамаарна/
- 1.7 Дүнгийн хуудаснууд, шалгалтын материал, докторын ажлын дэвтэр /2011 оноос өмнөх элсэгчдэд хамаарна/
- 1.8 Дүнгийн нэгдсэн тодорхойлолт /Сиси-ээс хэвлэгдсэн, баталгаажсан байх/
- 1.9 Кредит дүйцүүлсэн бол комисс томилсон шийдвэр болон комиссын шийдвэр
- 1.10 Төлбөрийн тооцоогүйг батлах баримт болон хамгаалалтын зардлыг бүрэлдэхүүн сургуульд тушаасан баримт /баталгаажсан байх/
- 1.11 Эрдэм шинжилгээний багц цаг тооцох комисс томилсон бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаал болон багц цаг тооцсон комиссын шийдвэр /баталгаажсан байх/
- 1.12 Тэнхим хэлэлцсэн протокол /2-оос доошгүй удаагийн/
- 1.13 Урьдчилсан хамгаалалт хийсэн протокол
- 1.14 Урьдчилсан хамгаалалтаас гарсан санал, шүүмжийг зассан протокол, хүснэгт /баталгаажсан байх/
- 1.15 Диссертацийн хураангуй /3 хуудас танилцуулга англи хэл дээр/
- 1.16 Удирдагчийн тодорхойлолт
- 1.17 Хамгаалалтад оруулах тухай бүрэлдэхүүн сургуулийн тодорхойлолт
- 1.18 Хамгаалалтад оруулахыг хүссэн хувийн өргөдөл
- 1.19 Докторын диссертацийн эх /1 хувь/

Бусад

1. Сургалтын журмын 4.12.4.8-ын дагуу багц цагаа дуусган гэрчилгээ авсан магистрант, докторант нь эрдэм шинжилгээний ажил, судалгааны ажлаа хамгаалах бол хүсэлтээ бичгээр бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд гаргана.

2. Сургалтын алба хүсэлтийг хүлээн авч улирлын эхэнд сургалтын мэдээллийн системд суралцагчийг идэвхтэй төлөвт шилжүүлнэ.

УХД0072 9104399

3. Сургалтын журмын 4.12.4.8-д заасан хамгаалах хүчинтэй хугацаа дууссан бол бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба мэдэгдэл өгч албажуулсаны дараа МУИС-ийн захирлын тушаалаар хасах тушаал гаргана. Хасах тушаалд орсон суралцагчийг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба сургалтын мэдээллийн системд сургуулиас хассан төлөвт шилжүүлнэ.

4. МУИС-ийн магистрант нь ахисан түвшний гадаад хэлний мэдлэгтэй байх бөгөөд англи хэлний хувьд TOEFL, IELTS-ийн, бусад хэлний хувьд мэргэжлийн хэлний мэдлэгийн түвшинг тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын байгууллагын харгалзах түвшний онооноос дээш оноотой эсвэл МУИС-ийн гадаад хэлний төвийн шалгалтаар амжилттай дүгнэгдсэн бол шаардлага хангасан гэж үзнэ. Ахисан түвшний гадаад хэлний хичээлийг МУИС дээр амжилттай судалсан бол шалгалт өгөх шаардлагагүй болзол хангасан гэж үзнэ.

5. Магистрын хөтөлбөр хооронд шилжих (өөр чиглэлийн хөтөлбөр, судалгааны, мэргэжлийн хөтөлбөр хооронд) асуудлыг "Суралцагч шилжүүлэн суралцуулах журам"-аар зохицуулна.